**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 08 өдөр Дугаар А/191 Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 3/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 21, 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 27, 28 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд "COVID-19"-ын цар тахалын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн аймгийн постуудад ажил үүрэг гүйцэтгэсэн байгууллагуудын үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн зардалд 50687026.00 төгрөг /тавин сая зургаан зуун наян долоон мянга хорин зургаан/-ийг 1 дүгээр хавсралтаар, халдварын хавьталтай иргэдийг тусгаарлах ажиллагааны үеийн зардалд 39120000.00 төгрөг /гучин есөн сая нэг зуун хорин мянган/-ийг 2 дугаар хавсралтаар, нийт 89807026.00 төгрөг /наян есөн сая найман зуун долоон мянга хорин зургаан/-ийг баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 89807026.00 төгрөгийг аймгийн техник хяналтын зардлын данснаас дараа тооцоогоор зохицуулж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн техник хяналтын зардлаас дараа тооцоогоор санхүүжүүлсэн 89807026.00 төгрөгийг аймгийн 2021 оны төсөвт тухайн зардлын батлагдсан эх үүсвэрээс нөхөн тооцоо хийж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/191-Bo

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны
өдрийн А/191 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт

## КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖИЛЛАСАН АЛБА ХААГЧДЫН ЗАРДЛЫН ТООЦООНЫ НЭГТГЭЛ

| Д\д | Аврах ажиллагааны нэр | Хугацаа | | Гүйцэтгэсэн даалгавар | | Нийт Ажилласан | | нийт хоног | Бусад зардал | | | | | | | | цалин | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эхэлсэн | дууссан | Гамшгийн төрөл | | хүн | хоног | | Тээвэр, шатахуун | Хоол | бичиг хэрэг | бараа материалын зардал | байрны зардал | эм эмийн хэрэгсэл | Холбоо-ны зардал | Гэрэл,Түлшний зардал | | |
| 1 | Жаргалант сум | 2021.02.22 | 2021.03.31 | ковид-19 | үндсэн пост, шуурхай штаб | 14 | 38 | 532 | 1,254,000 | 7,980,000 | 672,500 | | | | 183000 | 125,000 | | 10,214,500 |
| | Эрдэнэ-бүрэн | 2021.02.22 | 2021.03.31 | ковид-19 | Шургийн гүүр | 7 | 16 | 112 | 560,000 | 1,680,000 | | | | | | | | 2,240,000 |
| 2 | Манхан ОБГ | 2021.02.22 | 2021.03.31 | ковид-19 | пост | 2 | 38 | 76 | 940,500 | 760,000 | | | | | | | | 1,700,500 |
| 3 | Булган ОБХ | 2021.02.20 | 2021.03.31 | ковид-19 | пост солигдох, | | | | 284,000 | | | | | | | | | 284,000 |
| 4 | ОБГ | 2021.03.17 | 2021.03.18 | ЭМГ-аас эмч ковид 19 сургалтанд хамрагдах | | | | | 544,500 | | | | | | | | | 544,500 |
| 5 | Зэрэг ГТУА-70 анги | 2021.02.22 | 2021.03.31 | ковид-19 | Дарви сум пост солигдох | | | | 99,000 | | | | | | | | | 99,000 |
| 6 | Тусгаарлах байр | 2021.03.17 | 2021.03.25 | 1-р хавьтлын иргэдийг тусгаарлах ОБГ, цагдаа | | 8 | 6 | 48 | 536,250 | 720,000 | | | | | | | | 1,256,250 |
| | | 2021.03.18 | 20213.03.25 | ковид-19 | Өргөө зочид буудал | 13 | 4 | 52 | | 780,000 | | | 2,640,000 | | | | | 3,420,000 |
| Дүн | | | | | | | | | 4,218,250 | 11,920,000 | 672,500 | - | 2,640,000 | | 183,000 | 125,000 | - | 19,758,750 |
| 7 | Цагдаагийн газар | 2021.01.01 | 2021.03.24 | ковид-19 | Хяналт шалгалт Дарви, хонгио, мянгад, манхан | | | | 3,316,500 | | | | | | | | | 3,316,500 |
| 8 | Мянгад сум | 2021.02.01 | 2021.02.15 | ковид-19 | Мянгадын гүүр | 6 | 15 | 90 | | 1,018,000 | | | | | | | | 1,018,000 |
| 9 | Дарви сум | 2021.01.01 | 2021.01.30 | ковид-19 | ТАХ | | | | | 420,000 | | | | | | | | 420,000 |
| | | 2021.02.01 | 2021.02.28 | ковид-19 | пост | 21 | 28 | 588 | 579,550 | 8,820,000 | | 128,414 | | | | 232,159 | 600,000 | 10,360,123 |
| | | 2021.03.01 | 2021.03.31 | ковид-19 | пост | 21 | 31 | 651 | 320,050 | 9,765,000 | | | | | | | | 10,085,050 |
| 10 | Эрдэнэбүрэн сум | 2021.01.26 | 2021.02.28 | ковид-19 | Шургийн гүүр | | | | 1,611,910 | 550,000 | | | | | 92,000 | 970,500 | | 3,224,410 |
| 11 | ЗӨСТ | | | ковид-19 | | | | | | | | | | 1,234,693 | | | | 1,234,693 |
| 12 | АТГазар | 2021.01.01 | 2021.02.29 | ковид-19 | Хяналт шалгалт | | | | 846,500 | | | | | | | | | 846,500 |
| 13 | БОЭТөв | | | | | | | | 423,000 | | | | | | | | | 423,000 |
| Дүн | | | | | | | | | 7,097,510 | 20,573,000 | - | 128,414 | - | 1,234,693 | 92,000 | 1,202,659 | 600,000 | 30,928,276 |
| Нийт | | | | | | | | | 11,315,760 | 32,493,000 | 672,500 | 128,414 | 2,640,000 | 1,234,693 | 275,000 | 1,327,659 | 600,000 | 50,687,026 |

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны
өдрийн А/191 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

## КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖИЛЛАСАН АЛБА ХААГЧДЫН ЗАРДЛЫН ТООЦООНЫ НЭГТГЭЛ

| Д\д | Аврах ажиллагааны нэр | Хугацаа | | Гүйцэтгэсэн даалгавар | | Нийт Ажилласан | | нийт хоног | Бусад зардал | | | | | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эхэлсэн | дууссан | Гамшгийн төрөл | | хүн | хоног | | Тээвэр, шатахуун | Хоол | бичиг хэрэг | бараа материалын зардал | байрны зардал | |
| 1 | ОБГазар | 2021.03.30 | 2021.04.04 | ковид-19 | үндсэн пост, шуурхай штаб | 15 | 6 | 90 | 99,000 | 1,350,000 | 950,000 | 1,400,000 | | 3,799,000 |
| | ОБГазар | 2021.03.30 | 2021.04.04 | ковид-19 | Нэмэлт жижүүр | 21 | 6 | 153 | 99,000 | 2,295,000 | | | | 2,394,000 |
| | ОБГазар | 2021.03.30 | 2021.04.04 | ковид-19 | Нээлт пост, Уулзвар цагдаа | | 6 | 214 | 1,138,500 | 3,210,000 | | | | 4,348,500 |
| | ОБГазар | 2021.04.02 | 2021.04.04 | ковид-19 | Цагаан уул,Зооноз эмч нар шинжилгээний цэг | | 6 | 153 | 198,000 | 2,295,000 | | | | 2,493,000 |
| 2 | Тагнуул | 2021.04.03 | 2021.04.04 | ковид-19 | Тандалтын баг | 7 | 2 | 14 | | 210,000 | | | | 210,000 |
| 3 | Ховд их сургууль | 2021.03.31 | 2021.04.04 | ковид-19 | Иргэдийг тусгаарлах | | 6 | 440 | | 6,600,000 | | | 4,400,000 | 11,000,000 |
| 4 | Цамбагарав зочид буудал | 2021.04.03 | 2021.04.04 | ковид-19 | Иргэдийг тусгаарлах | | 2 | 38 | | 570,000 | | | 2,070,000 | 2,640,000 |
| 5 | WELL зочид буудал | 2021.04.03 | 2021.04.04 | ковид-19 | Иргэдийг тусгаарлах | | 2 | 32 | | 480,000 | | | 1,130,000 | 1,610,000 |
| 6 | Өргөө | 2021.03.31 | 2021.04.05 | ковид-19 | Иргэдийг тусгаарлах | | 5 | 114 | | 1,710,000 | | | 5,405,000 | 7,115,000 |
| 7 | Улаанбаатар хот | 2021.04.04 | | ковид-19 | Вакцин авч ирэх | | | | 919,000 | 200,000 | | | | 1,119,000 |
| 8 | Хүүхэд хамгаалал | 2021.04.03 | 2021.04.05 | ковид-19 | | | 3 | | 49,500 | | | | | 49,500 |
| 9 | Явуулын шинжилгээний баг | | | | | | | | 190,000 | | | | | 190,000 |
| 10 | Тусгаарлагдсан иргэдийг ар гэрт нь хүргэж өгөх | | | | | | | | 152,000 | | | | | 152,000 |
| 11 | ЭМГазар | | | Ковид-19 | Нэг удаагийн улавч | | | | | | | 2000000 | | 2000000 |
| Дүн | | | | | | | | 1,248 | 2,845,000 | 18,920,000 | 950,000 | 3,400,000 | 13,005,000 | 39,120,000 |